

5. Эрүүл мэндээ хамгаалуулах эрх

33. Монгол Улсын Үндсэн хуульд "... эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлнэ..." гэж заасны дагуу иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламжийг алагчлалгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлж байна.

Монгол Улсад Иргэний эрүүл мэндийн даатгалын тогтолцоог 1994 онд бий болгож эрүүл мэндтэй холбоотой зардлын улмаас санхүүгийн эрсдэлд орохоос иргэдээ хамгаалах боломжийг бүрдүүлэв. УИХ-аас баталсан 2008-2012 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт Эрүүл мэндийн салбарт 22 зорилт тусгагдсан бөгөөд эдгээр зорилтыг хэрэгжүүлэхээр Засгийн газар 96 зүйл бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан ажиллаж байна.

34. Монгол Улс зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг 1991 онд анх боловсруулан гаргаж, эмчилгээнд мөрдөж эхэлснээс хойш Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (цаашид "ДЭМБ" гэх) болон бусад орнууд зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтаа тодорхой хугацаанд шинэчлэж байдаг туршлага, эмийн зах зээлтэй уялдуулан эмчилгээний арга барилд гарч буй өөрчлөлт, өвчлөлийн байдал, эмийн бүртгэл, ханган нийлүүлэлт, эмч, эм зүйч нарын саналыг үндэслэн 1993, 1996, 2001, 2005, 2009 онуудад тус тус шинэчилсэн. Эмийн төсөвт жилд 29 орчим тэрбум төгрөг зарцуулж, нэг хүнд ноогдох эмийн зардал ойролцоогоор 8 ам.доллар (13.0 мянган төгрөг), эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 1 өвчтөнд дунджаар 6.95 нэр төрлийн эм хэрэглэж байна.

35. Эрүүл мэндийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төрийн оролцоог багасгах зорилгоор хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад хувийн хэвшлийн мэргэжлийн эмнэлгийн оролцоог дэмжих зорилгоор эрүүл мэндийн салбарын санхүүжилтэд хувийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, өмчийн хэлбэрийг үл харгалзан эмнэлгүүдийг даатгалын үйлчилгээнд жигд хамруулах зорилтын хүрээнд 2009 онд эрүүл мэндийн даатгалын сангаас 56.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын болон хувийн хэвшлийн байгууллагуудыг санхүүжүүлж, 2010 онд нийт 76 тэрбум төгрөгийн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг санхүүжүүлэхээр болов.

36. "Эрүүл монгол хүн" хөтөлбөр Монгол Улсын Засгийн газрын 91 дүгээр тогтоолоор батлагдаж 2006-2008 онд хэрэгжсэн. Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний өвчлөлийн түвшинг тогтоон, эрт илрүүлэн эмчилснээр хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулахад хөтөлбөрийн зорилго оршино. Уг хөтөлбөр улсын хэмжээнд нэгдсэн удирдамж, төлөвлөгөө, аргачлалын дагуу хэрэгжсэнээр хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, тэгш байдал, чанарт эерэгээр нөлөөлж байгаагаас гадна сонгогдсон өвчнүүдийг эрт илрүүлэн, эмчилгээнд хамруулснаар үр дүнгээ өгсөн. Ялангуяа, бэлгийн замаар дамжих халдвар, умайн хүзүүний хавдар, цусны даралт ихсэх өвчний эрт илрүүлэлт, эмчилгээ, эрүүлжүүлэлтийн хувь өндөр гарлаа. "Эрүүл монгол хүн" хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 15-аас дээш насны 1.020.705 хүн буюу нийт хүн амын 83.6 хувь хамрагджээ.